



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТОДОРХОЙЛОЛТ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Энхтайвны гудамж 136, Утас 7012-8801
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2023.04.03 № 236
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв эмнэлгүүдээс 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 7 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА



142104090609

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 450 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь 2023 оны 2 сараас 24 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 94% /421/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн
хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	2	85	87
2	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	2	53	55
3	Толгой, хүзүүний мэс засал	5	50	55
4	Хими	3	45	48
5	Ерөнхий мэс засал	2	42	44
6	Хөхний төв	2	41	43
7	Туяа эмчилгээ	-	41	41
8	Зүрх судас судлал	8	19	27
9	Ангиографи	-	21	21
10	Элэг судлал	1	20	21
11	Цээжний хөндийн мэс засал	4	3	7
12	Сэргээн засах	-	1	1
	Нийт	29	421	450

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 87 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 19 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байгаа боловч эмнэлгийн хэмжээнд хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна. Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын эмчид үзүүлэхээр 55, Хими эмчилгээний зүлэгт орохоор 48, Толгой, хүзүүний мэс заслын эмчид үзүүлэхээр 55 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Хавдар судлалын үндэсний төвийн оношилгооны хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	КТГ		7	45	52
2	ЭКГ	-	6	18	24
3	Хэвлийн эхо	-	5	14	19
4	Маммографи	-	-	16	16

5	Ходоодны дуран	-	4	6	10
6	Рентген харалт	-	-	4	4
7	Зүрхний эхо	-	2	1	3
8	БШГМЗ Дуран	-	2	-	2
	НИЙТ	-	26	104	130

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 130 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна. Хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд КТГ-ийн оношилгоо хамаарч байгаа ба нийт 52 үйлчлүүлэгч 4-с дээш хоног хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн 40 %-ийг дангаараа эзэлж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй, нийт 588 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 65 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

Эмнэлгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				БҮГД
	3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
ХСҮТ	44	166	302	76	588

Ор хүлээж буй үйлчлүүлэгчдийн тал хувь нь /51% ; 302 үйлчлүүлэгч/ 15-30 хоног хүлээгдэлтэй байна. Тус эмнэлгээс орны хүлээгдлийг тасаг бүрээр ирүүлээгүй байна.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлэг амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийн мэдээ г ирүүлээгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй, 1532 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	15
		7-14 хоног	27
		15-30 хоног	51
		1 сараас дээш	442
	Нийт		535
2	Нүдний тасаг	3-6 хоног	47
		7-14 хоног	63
		15-30 хоног	102
		1 сараас дээш	232
	Нийт		444
3	БШГМЗ тасаг	3-6 хоног	22
		7-14 хоног	24
		15-30 хоног	43
		1 сараас дээш	104
	Нийт		193

4	Урологийн тасаг	3-6 хоног	30
		7-14хоног	42
		15-30 хоног	30
		1 сараас дээш	30
	Нийт		132
5	Мэс заслын тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	48
		15-30 хоног	76
		1 сараас дээш	-
	Нийт		131
6	Зүрх судас судлал	3-6 хоног	2
		7-14хоног	6
		15-30 хоног	8
		1 сараас дээш	14
	Нийт		30
7	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	10
		7-14хоног	7
		15-30 хоног	6
		1 сараас дээш	-
	Нийт		23
8	Цусны эмгэг судлал	3-6 хоног	5
		7-14хоног	6
		15-30 хоног	6
		1 сараас дээш	-
	Нийт		17
9	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	12
		7-14хоног	1
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
	Нийт		13
10	Бөөр судлал	3-6 хоног	2
		7-14хоног	3
		15-30 хоног	-
	Нийт		5
11	Хэрх үе	3-6 хоног	2
		7-14хоног	2
	Нийт		4
12	Мэдрэл судлал	15-30 хоног	2
		1 сараас дээш	1
	Нийт		3
13	Уушиг судлал	3-6 хоног	2
	Нийт		2
	БҮГД	3-6 хоног	156
		7-14хоног	229
		15-30 хоног	324
		1 сараас дээш	823
	НИЙТ		1532

Чих хамар хоолойн тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр нийт 535 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь эмнэлгийн хэмжээнд нийт орны хүлээгдлийн 1/3 /35%/-ийг эзэлж байгаа ба эдгээр үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 82% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар

хүлээгдэлтэй байна. Мөн Нүдний тасагт хэвтэхээр 444 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс даруй 173 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хүлээгдэлтэй тусламж, үйлчилгээний 3 дугаарт БШГМЗаслын тусламж үйлчилгээ орж байгаа ба 193 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн тал хувь нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна.

Тус эмнэлэг оношилгооны чиглэлээр мөн тусламж, үйлчилгээний хүлээгдэл ихтэй ажиллаж байна. /Хүснэгт 5 /

Хүснэгт 5. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	
1	КТГ	108	180	360	648
2	MRI	30	50	70	150
3	Урологийн дурангийн оношилгоо	11	-	-	11
4	Хэвлийн эхо		8		8
5	Рентген зураг	3	-	-	3
6	ЭКГ	1	-	-	1
7	Захын судасны эхо	1	-	-	1
	НИЙТ	154	238	430	822

КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 648 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн дийлэнх буюу 79%-ийг эзэлж байна. Мөн нийт хүлээгдлийн тал орчим хувь нь 15-30 хоногийн хүлээгдэлтэй байна.

3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ өмнөх саруудтай харьцуулахад хүлээгдэл ихтэй байна. Нийт 147 үйлчлүүлэгч амбулаторийн 10 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 85 үйлчлүүлэгчээр ихэссэн үзүүлэлттэй байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэдрэл судлал, Нүдний эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	4	40	46
2	Мэдрэл судлал	1	-	24	25
3	Нүд судлал	-	-	22	22
4	Эмэгтэйчүүд судлал	9	7	4	20
5	Мэс засал судлал	-	1	14	15

6	Бөөр судлал	-	1	12	13
7	Зүрхний эмгэг судлал	-	-	2	2
8	Уушигны эмгэг судлал	1	-	1	2
9	Чих хамар хоолой судлал	1	-	-	1
10	Урологи	1	-	-	1
	НИЙТ	15	13	119	147

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр 147 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 81% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 67 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Хэвлийн эхо-д харуулахаар 36, Рентген оношилгоо хийлгэхээр 19, MRI оношилгоо хийлгэхээр 12 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна. Шинжилгээ өгөхөөр нийт 35 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 20 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл маш ихтэй байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 379 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 170 үйлчлүүлэгч ор хүлээж байна. /Хүснэгт 6/.

Хүснэгт 6. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Мэс засал судлал	82	88	-	-	170
2	Чих, хамар, хоолой судлал	-	51	39	-	90
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	20	13	25	-	58
4	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	8	16	4	-	28
5	Зүрх судасны эмгэг судлал	5	7	-	-	12
6	Урологи	7	3	-	-	10
7	Мэдрэл судлал	6	-	-	-	6
8	Уушиг судлал	3	-	-	-	3
9	Бөөрний эмгэг судлал	2	-	-	-	2
	НИЙТ	133	178	68	-	379

Мөн Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 90 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хэвтүүлэн эмчлүүлэхээр хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 82% /311/ нь 2 долоо хоног хүртэл хугацаагаар ор хүлээж байна.

4. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн зүрх судасны эмчид үзүүлэхээр 34, мэдрэлийн эмчид үзүүлэхээр 26 үйлчлүүлэгч 3 хоног хүлээж байгаа ба амбулаторийн бусад чиглэлийн эмчийн үзлэг хүлээгдэлгүй байна. Хэвлийн эхо-д харуулахаар 17 үйлчлүүлэгч 3-6 хоног, зүрхний эхо-д харуулахаар 18 үйлчлүүлэгч 3-6 хоног, 5

үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд тус тус хамаарч байна. 2023 оны 3 сард тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ нь хүлээгдэл ихтэй байна. /Хүснэгт 7/.

Хүснэгт 7. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Цусны шинжилгээ	20	22
2	Бактерлогийн шинжилгээ	22	5
3	Биохимийн шинжилгээ	25	-
4	Шээсний шинжилгээ	21	-
	НИЙТ	88	27

Цусны шинжилгээ хийлгэхээр 42, бактерлогийн шинжилгээ хийлгэхээр 27 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэл шинжилгээнд хамаарч байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 206 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байна. Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 120 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн тал хувийг эзэлж байна. /Хүснэгт 8 /

Хүснэгт 8. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 3 тасгийн мэдээ

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	-
		7-14хоног	10
		15-30 хоног	30
		1 сараас дээш	80
		Нийт	120
2	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	14
		15-30 хоног	1
		1 сараас дээш	-
		Нийт	22
3	Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	3
		15-30 хоног	1
		1 сараас дээш	-
		Нийт	19
	БҮГД		161

5. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 25 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна./ Хүснэгт 9/

Хүснэгт 9. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
---	-------------------	---------------------------------

1	3 хоног	10
2	4-6 хоног	5
3	7-с дээш хоног	10
	Нийт	25

Тус эмнэлэгт MRI оношилгооны багаж эвдэрсний улмаас шинжилгээ хийлгэхээр 387 үйлчлүүлэгч 15-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Мөн рентген шинжилгээ хийлгэхээр 17, хэвлийн эхо-д харуулахаар 2 үйлчлүүлэгч тус бүр 2-с дээш хоногийн хүлээгдэлтэй байлаа. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ харьцангуй хүлээгдэл багатай, нийт 17 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна.

6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл 2 сартай харьцуулахад бараг 3 дахин буурсан үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 44 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 72 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь 2 сарын үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна. 19 үйлчлүүлэгч 3-6 хоног, 42 үйлчлүүлэгч 7-14 хоног, 11 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус ор хүлээж байна.

7. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 154 үйлчлүүлэгч 3-6 хоног, 96 үйлчлүүлэгч 7-14 хоног, 59 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 309 хүн хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. MRSA халдвар эмчлүүлэхээр 7 үйлчлүүлэгч 7-14, 3 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус хүлээж байна.

8. Хүрээ амаржих газар ТМЭ, Геронтологийн үндэсний төв нь 2023 оны 3 дугаар сард хүлээгдэлгүй ажиллаж байна.
9. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.